



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/110/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он
Цахим хуудас: www.audit.mn

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Цэрэнчимэд

Утас: 88302569 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА
М.МЭНДЖАРГАЛ ТАНАА

2019.02.25 № 2/108
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод

D:\СТА-2018\Биеийн тамир спортын газар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2519701

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\STA-2018\Биеийн тамир спортын газар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга М.Мэнджаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 24-нөөс 2019 оны 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар нь “Спортын бүх төрлийг жигд өндөр түвшинд хөгжүүлж, нийтийн биеийн тамирын арга хэмжээг чанаржуулж, хамрах хүрээг өргөтгөх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын гарын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,0 хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 646575,9 мянган төгрөг бөгөөд түүний 2,0 хувь болох 12931,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	0.00	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас бараа материалын тайланд 586,0 мянган төгрөгийн залруулга хийлээ.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Спортын уралдаан тэмцээнд зарцуулсан мөнгөний зарцуулалтын гүйцэтгэлийн тайланг тухайн уралдаан тэмцээний батлагдсан төлөвлөгөө, удирдамж, хөтөлбөрийн дагуу тухай бүр бүрэн гаргаж байх, зах зээлийн үнээс өндөр үнээр медаль хийлгэх, худалдан авахыг зогсоох, бараа материалын тайланг бараа материалын нэр төрлөөр нь стандарт маягтын дагуу сар бүр гаргаж байх зэрэг асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 507198,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв,

гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 17 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчийг байгууллагын даргын тушаалаар шийтгэлийг нь цагаатгаж, УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын заалтыг зөрчиж урамшуулал олгосныг Дотоод аудит санхүүгийн хяналтын байгууллагаар хянуулж шийдвэрлүүлэх гэсэн зөвлөмж хэрэгжээгүй, биеийн тамирын уралдаан тэмцээний зардлыг оны эхэнд арга хэмжээ, хөтөлбөр тус бүрээр төлөвлөж, баталгаажуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Биеийн тамирын уралдаан тэмцээнд зарцуулсан зардлын тайланг тэмцээн тус бүрээр бүрэн гаргаагүй, тамирчдын шагналд олгосон медалийг зах зээлийн үнээс хэт өндөр үнээр худалдан авсан зөрчил илэрлээ. Тухайлбал: Иргэдийн спортын их наадмын шагналд олгосон 228 медалийг нэг бүрийг нь 20,0 мянган төгрөгөөр буюу нийт 4560,0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.
2. Бараа материалын тайланг стандартын маягтаар гаргаагүй зөрчил илэрлээ. Дээрхи алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлээ.
 1. Спортын уралдаан тэмцээнд зарцуулсан зардлын гүйцэтгэлийн тайланг тухайн уралдаан тэмцээн бүрээр батлагдсан төлөвлөгөө, удирдамж, хөтөлбөрийн дагуу тухай бүр тусгайлан гаргаж байх, зах зээлийн үнээс өндөр үнээр медаль хийлгэх, худалдан авахыг зогсоох, бараа материалын тайланг бараа материалын нэр төрлөөр нь стандарт маягтын дагуу сар бүр гаргаж байх гэсэн зөвлөмжийг хүргүүлээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,779,500.00	28,319,612.00
33	АВЛАГА	00.00	16,202,000.00
335	Бусад авлага	00.00	16,202,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	16,202,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,779,500.00	12,117,612.00
354	Хангамжийн материал	11,779,500.00	12,117,612.00
35420	Аж ахуйн материал	3,775,650.00	4,120,362.00
35450	Барилгын засварын материал	6,600.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	7,997,250.00	7,997,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,735,196,832.64	4,991,400,780.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,735,196,832.64	4,991,400,780.21
392	Биет хөрөнгө	3,734,536,832.64	4,470,527,780.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,002,378,607.00	3,612,717,816.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-121,520,540.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,269,710.00	47,269,710.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,324,411.16	-35,733,363.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,160,140.00	79,510,140.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,498,747.00	-43,325,982.00
39209	Зам, гүүрийн байгууламж	135,000,000.00	135,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-13,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	140,000.00	140,000.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	809,970,000.00	809,970,000.00
393	Биет бус хөрөнгө	660,000.00	520,873,000.00
39301	Програм хангамж	660,000.00	660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-165,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	520,378,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,746,976,332.64	5,019,720,392.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,213.65	11,269.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,213.65	11,269.00
413	Өглөг	14,213.65	11,269.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,746,962,118.99	5,019,709,123.21
51	Засгийн газрын хувь оролцоо	3,746,962,118.99	5,019,709,123.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	455,232,973.58	975,610,973.58
51101	Өмч: - төрийн	455,232,973.58	975,610,973.58
512	Хуримтлагдсан үр дүн	2,881,223,388.37	2,873,678,993.02
51210	Өмнөх үеийн үр дүн	2,881,223,388.37	2,881,223,388.37
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-7,544,395.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	410,505,757.04	1,170,419,156.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,746,976,332.64	5,019,720,392.21

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,037,028,001.00	639,031,604.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,301,800.00	89,556,931.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,301,800.00	89,556,931.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,301,800.00	89,556,931.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,196,500.00	19,700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,420,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,685,300.00	69,856,931.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	490,345,201.00	42,276,473.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	330,000.00	00.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	330,000.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	506,381,000.00	507,198,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,469,500.00	40,875,560.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,469,500.00	32,657,760.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,217,800.00
1330	Төсвийн захирагчдаас	473,541,959.00	00.00
133003	Хөрөнгийн	473,541,959.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,003,742.00	1,400,913.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,003,742.00	1,400,913.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	624,507,781.51	646,575,999.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624,507,781.51	646,575,999.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	588,205,674.51	644,753,894.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,132,500.00	142,354,108.00
210101	Үндсэн цалин	130,132,500.00	142,354,108.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,329,013.65	17,246,062.51
210201	Тэтгэврийн даатгал	14,329,013.65	15,147,710.51
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	506,712.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	528,371.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	96,661.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	966,608.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302,882,519.00	311,912,125.00
210301	Гэрэл, цахилгаан	5,022,066.00	5,283,466.00
210302	Түлш, халаалт	293,204,273.00	302,101,359.00
210303	Цэвэр, бохир ус	4,656,180.00	4,527,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,911,699.00	5,118,907.65
210401	Бичиг хэрэг	1,653,355.00	1,913,090.00
210402	Тээвэр, шатахуун	1,361,800.00	674,630.15
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	603,544.00	861,769.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	293,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,169,418.00
2105	Нормативт зардал	435,380.00	00.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	435,380.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,047,485.00	6,443,700.00
210604	Урсгал засвар	10,047,485.00	6,443,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,006,300.00	994,000.00
210702	Дотоод албан томилолт	1,006,300.00	994,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,357,647.00	27,133,087.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,865,500.00	26,407,759.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	91,900.00	91,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	19,875.00	127,500.00
210807	Газрын төлбөр	166,648.00	265,828.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	213,724.00	240,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,103,130.86	133,551,902.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,962,223.00	41,107,519.93
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,140,907.86	92,444,383.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,302,107.00	1,822,105.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,793,742.00	1,400,913.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,003,742.00	1,400,913.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,425,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,365,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,508,365.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,508,365.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	421,192.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	421,192.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	412,520,219.49	-7,544,395.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,009,743.07	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,009,743.07	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-11,009,743.07	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	401,510,476.42	-7,544,395.35

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	559,470,742.00	569,174,673.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,616,500.00	19,700,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,616,500.00	19,700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,616,500.00	19,700,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,196,500.00	19,700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,420,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	522,854,242.00	549,474,673.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	506,381,000.00	507,198,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,469,500.00	40,875,560.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,469,500.00	32,657,760.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,217,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,003,742.00	1,400,913.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,003,742.00	1,400,913.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	559,470,742.00	569,174,673.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	559,470,742.00	569,174,673.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	522,683,635.00	551,150,567.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,132,500.00	142,473,300.00
210101	Үндсэн цалин	130,132,500.00	142,473,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,314,800.00	17,129,815.16
210201	Тэтгэврийн даатгал	14,314,800.00	14,677,338.16
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	582,124.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	541,842.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	98,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,230,311.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302,882,519.00	314,101,225.00
210301	Гэрэл, цахилгаан	5,022,066.00	5,283,466.00
210302	Түлш, халаалт	293,204,273.00	302,101,359.00
210303	Цэвэр, бохир ус	4,656,180.00	6,716,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,230,244.00	6,105,619.50
210401	Бичиг хэрэг	941,900.00	2,018,220.00
210402	Тээвэр, шатахуун	1,361,800.00	674,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	623,544.00	861,769.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	303,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,051,000.00
2105	Нормативт зардал	387,100.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	387,100.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,981,025.00	2,000,000.00
210602	Тавилга	2,800,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,181,025.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	730,300.00	994,000.00
210702	Дотоод албан томилолт	730,300.00	994,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,822,147.00	29,522,188.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,330,000.00	28,796,860.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	91,900.00	91,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	19,875.00	127,500.00
210807	Газрын төлбөр	166,648.00	265,828.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	213,724.00	240,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,203,000.00	38,824,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,203,000.00	38,824,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,787,107.00	18,024,105.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,278,742.00	1,400,913.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,003,742.00	1,400,913.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,425,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,850,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,508,365.00	16,202,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,508,365.00	16,202,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	421,192.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	421,192.34

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	455,232,973.58	410,505,757.04	2,479,712,911.95	3,345,451,642.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	455,232,973.58	410,505,757.04	2,479,712,911.95	3,345,451,642.57
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	401,510,476.42	401,510,476.42
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	455,232,973.58	410,505,757.04	2,881,223,388.37	3,746,962,118.99
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	455,232,973.58	410,505,757.04	2,881,223,388.37	3,746,962,118.99
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	759,913,399.57	00.00	759,913,399.57
Тайлант үеийн үр дүн	520,378,000.00	00.00	-7,544,395.35	512,833,604.65
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,610,973.58	1,170,419,156.61	2,873,678,993.02	5,019,709,123.21

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	526,798,200.00	526,477,007.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	526,798,200.00	526,477,007.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	526,798,200.00	526,477,007.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,473,300.00	142,473,300.00
210101	Үндсэн цалин	142,473,300.00	142,473,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,096,800.00	17,129,815.16
210201	Тэтгэврийн даатгал	11,397,600.00	14,677,338.16
210202	Тэтгэмжийн даатгал	1,424,700.00	582,124.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,408,900.00	541,842.00
210204	Ажилгүйдлийн даатгал	284,800.00	98,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,580,800.00	1,230,311.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	314,468,100.00	314,101,225.00
210301	Гэрэл, цахилгаан	5,280,000.00	5,283,466.00
210302	Түлш, халаалт	302,418,100.00	302,101,359.00

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	6,770,000.00	6,716,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,760,000.00	6,089,819.50
210401	Бичиг хэрэг	1,420,000.00	2,002,420.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	674,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	861,769.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	2,051,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	994,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	994,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00	4,864,428.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,139,100.00	4,139,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	91,900.00	91,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	127,500.00	127,500.00
210807	Газрын төлбөр	365,800.00	265,828.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	275,700.00	240,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39000000.00	38824420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,000,000.00	38,824,420.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	526,798,200.00	526,477,007.66
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	507,198,200.00	506,777,007.66
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	507,198,200.00	506,777,007.66
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	19,600,000.00	19,700,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,600,000.00	19,700,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13
620003	Үйлчлэх ажилтан	07	07
620004	Гэрээт ажилтан	06	06